УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын нийт албан хаагчдын санал хураалтаар олонхийн дэмжлэг авсан 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр Тамгын газрын Ёс зүйн дэд хороог 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн бүртгэлийг https://hrm.csc.gov.mn/ethics/memberdep цахим системд үүсгэж, мэдээллийг тухай бүр шинэчилж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлэхээр хуульд заасан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-т "төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг тогтмолжуулах"-аар туссан. Дэвшилтэт, шинэ үеийн парламентын хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, өндөр бүтээмжит ажлын албыг бэхжүүлэх стратегийн зорилт, Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчдад зориулсан "Ёс зүйн сургалт"-ыг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Энэ удаагийн сургалтад Монгол Улсын Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт" сэдвээр, Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн багш, Доктор (Ph.D), дэд профессор А.Алтанзул "Парламентын ажлын албаны ажилтны ёс зүйн олон улсын нийтлэг жишиг" сэдвээр тус тус танилцуулга хийсэн. Улсын Их Хурлын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга нар 2025 оны 03 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд Удирдлагын академиас зохион байгуулсан "Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах" сэдэвт сургалтад хамрагдаж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх онол, арга зүйн мэдлэг, ур чадварыг эзэмшсэн.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Хууль тогтоомжийн хүрээнд албан ажлыг шуурхай зохион байгуулах, ажлын уялдаа холбоог хангах, албан хаагчдын багаар ажиллах, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр албан хаагчидтай тогтмол уулзаж, санал хүсэлтийг сонсдог. Тухайлбал, өнгөрсөн онд удирдлагын түвшинд Хуулийн газар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын албан хаагчидтай уулзаж, санал хүсэлтийг сонсож, дэмжин ажиллаж байна. Түүнчлэн Ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсож, санал солилцож ажилладаг.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчид холбогдуулан 2 иргэн (албан хаагч)-ээс Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г зөрчсөн гэж үзэж гомдол гаргасан. Ёс зүйн дэд хороо гомдлыг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хүлээн авч, бүрдийг хангаж, хуралдаан зохион байгуулж, талуудаас тайлбар, мэдээлэл авч шалган шийдвэрлэсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн бүртгэл мэдээллийг Ёс зүйн бүртгэл, хяналтын цахим систем (https://hrm.csc.gov.mn/ethics/violationcomplain)-д бүртгэж, гомдол шалган шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг тухай бүр бүртгэж байна. Тамгын газрын Ёс зүйн дэд хороо нь Монгол Улсын Ёс зүйн хорооны 2023 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д заасны дагуу дэд хорооны дүгнэлт, хурлын тэмдэглэлийг албажуулах албан бичгийн хэвлэмэл хуудасны эхийг Архивын ерөнхий газарт хүсэлт гаргаж, хэвлэмэл хуудасны эхийг баталгаажуулсан. Улмаар Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг албажуулах ажиллагааг гүйцэтгэж, томилох эрх бүхий албан тушаалтанд дүгнэлтийг тухай бүр танилцуулж ажилласан. Ёс зүйн дэд хороо тайлант хугацаанд 2 иргэн (албан хаагч)-ий гаргасан гомдлын дагуу 7 удаа 9 цаг 29 минут хуралдсан байна. Мөн хянан шалгах чиг үүрэг бүхий гишүүд талуудаас тайлбар, мэдээлэл авах хүрээнд 4 удаагийн уулзалт зохион байгуулж, 1 цаг 40 минут уулзалт зохион байгуулсан. Тамгын газрын Ёс зүйн дэд хороо Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2023 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын хүрээнд өөрчлөлт оруулах санал боловсруулсан. Тодруулбал, хуулийн бүтэц, зохицуулах харилцаа, үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогчдын чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг хуульд тусгасан байдлыг авч үзвэл хуулийн үйлчлэх хүрээ нь хэт явцуу, бусад хуулийн заалттай давхардсан зохицуулалттай байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт, гомдол хянан шийдвэрлэх процессын талаар нэгдсэн мэдээлэл олгосон. Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга Удирдлагын академийн сургалтад хамрагдсан. Тус сургалтаар хууль хэрэглээний нэгдсэн ойлголт авсан.	Тамгын газрын Ёс зүйн дэд хороо Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2023 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын хүрээнд өөрчлөлт оруулах санал боловсруулсан. Тодруулбал, хуулийн бүтэц, зохицуулах харилцаа, үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогчдын чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг хуульд тусгасан байдлыг авч үзвэл хуулийн үйлчлэх хүрээ нь хэт явцуу, бусад хуулийн заалттай давхардсан зохицуулалттай байна.

Санал:
Улсын Их Хурлын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг хэрэглэхэд гарч буй хүндрэл, хууль тогтоомж хоорондын давхардал, хийдлийн талаар санал боловсруулсан.

Шалгах хэсэг:

- ☐ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга */Албан тушаал/*	_____ */Гарын үсэг/*	Л.Өлзийсайхан */Гарын үсгийн тайлал/*
УИХ-ын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны дарга */Албан тушаал/*	_____ */Гарын үсэг/*	Ш.Хишигсүрэн */Гарын үсгийн тайлал/*
УИХ-ын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны Нарийн бичгийн дарга */Албан тушаал/*	_____ */Гарын үсэг/*	Т.Түмэнцэцэг */Гарын үсгийн тайлал/*

Огноо: ..... оны ..... сарын .....

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлагдсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0.5	0.25	2.5
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0.5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0.5	0.5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн мэйл бөглөсөн байдал[9]	0.5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	1.75	17.5
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн мэдлэйлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гаргасан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	0.5	5
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0	0
Хэсгийн оноо				**3**	1.5	15
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	3	30
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**6.25**	**62.5**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".
[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, садан батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ

2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд дараах үндэслэлээр өөрчлөлт оруулах санал хүргүүлж байна. Үүнд:

1.Хуулийн бүтэц, зохицуулах харилцаа, үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогчдын чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг хуульд тусгасан байдлыг авч үзвэл хуулийн үйлчлэх хүрээ нь хэт явцуу, бусад хуулийн заалттай давхардсан зохицуулалттай байна. Тухайлбал,

i)хуулийн 1 дүгээр зүйлд "Төрийн албан хаагч ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх эрхэм зорилгоо ухамсарлаж, төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ **хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг** чандлан биелүүлэх үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлж, төрөө дээдлэх ард түмний итгэлийг бэхжүүлэхэд энэ хуулийн зорилго оршино." гэж, 5 дугаар зүйлд "төрийн албан хаагчийн нийтлэг хэм хэмжээ", "төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил", "төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага"-ыг тодорхойлсон байх бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д "**төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ**, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;" нь төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг **төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ**"-г журамласан.

Тодруулбал, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд "төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил"-ийг ёс зүйн зөрчилд, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;"-гүй байх нь сахилгын зөрчилд тооцогдохоор ялгаатай тодорхойлж, хариуцлагыг өөр өөрөөр ногдуулахаар хуульчилсан. Энэ нь өөр хоорондоо хамааралтай хуулиуд зөрчилдөх нөхцөлийг үүсгэж байна.

ii)хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа энэ хуулийн 7.1-д заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд **Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 8.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлд заасан үүргээс гадна** дараах нийтлэг үүргийг хүлээнэ:", 8.2-т "Төрийн албан хаагчид энэ хуулийн 7.1-д заасан нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд **Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалтаас гадна** дараах үйл ажиллагааг хориглоно:" гэж тус тус заасан. Өөрөөр хэлбэл, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл, 39 дүгээр зүйлд заасан нийтлэг үүрэг, хориглолт, хязгаарлалтаас гадна, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд

заасан нийтлэг хэм хэмжээ, нийтлэг шаардлагыг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан боловч хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "**Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8.1, 8.2-т заасныг зөрчсөн тохиолдолд** томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан Ёс зүйн хорооны, Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан дараах ёс зүйн хариуцлагын аль нэгийг ногдуулна:" гэсэн нь эрх зүйн тодорхойгүй байдлыг бий болгож, хууль хэрэглээний хүндрэл үүсгэж байна.

iii)хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д "Энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдол, мэдээлэл гаргасан этгээд түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор харьяалах дээд шатны байгууллагын Ёс зүйн дэд хороо, Ёс зүйн хороонд гомдол гаргаж болно." гэж заасан боловч ёс зүйн зөрчил гаргасан этгээдийн хувьд хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гаргаж болно." гэж зөрчил гаргасан этгээдийн гомдол гаргах эрхийг хязгаарласан шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, гомдол гаргагч нь харьяалах дээд шатны байгууллагын Ёс зүйн дэд хороо, Ёс зүйн хороонд гомдол гаргах эрхтэй байхад, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчийн хувьд "шүүхэд гомдол гаргах"-аар зохицуулсан байна.

iv)хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-т "Энэ хуулийн 11.3-т заасан орон тооны бус 4 гишүүнийг **Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо** томилж, чөлөөлнө." гэснийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5-д "Ёс зүй, дэгийн;" гэсэнтэй нийцүүлэх шаардлагатай байна.

v)хуулийн 17 дугаар зүйлд заасан "төрийн албан хаагч ёс зүйн хариуцлагыг сайн дурааараа хүлээх" зохицуулалтын хүрээнд 17.1-д заасан "Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр тухайн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дурааараа хүлээх боломж олгоно." гэснийг дэд хороо, эсхүл томилох эрх бүхий албан тушаалтан аль нь хэрэгжүүлэхийг тодорхой болгох нь зүйтэй байна.

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" нь нэр томьёо, хэл зүй, найруулгын хувьд оновчтой бус, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх, хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбар байх зэрэг хэл зүй, найруулгын шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал,

i)журмын 2.10-т "Дэд хорооны гишүүн нь гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй, **сахилгын болон ёс зүйн шийтгэл хүлээгээгүй**, шударга, хамт олондоо хүлээн зөвшөөрөгдсөн этгээд /төрийн албан хаагч байна" гэж хуульчилсан нь сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа өнгөрсөн албан хаагчийг Ёс зүйн дэд хорооны гишүүнд сонгогдох эрхийг хязгаарласан байна. Өөрөөр хэлбэл, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д "Төрийн жинхэнэ албан хаагч **сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно**." гэж, мөн

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6-д "Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно." гэж тус тус заасан байтал хуульд заасан хугацаа дууссан буюу "сахилгын шийтгэлгүйд тооцох", "ёс зүйн шийтгэлгүйд тооцох" хугацаа өнгөрсөн албан хаагчийн сонгогдох эрхийг хязгаарласан.

ii)хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т Ёс зүйн дэд хороо "харьяа байгууллага, бүтцийн **нэгжид ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх**;" бүрэн эрхтэй гэж хуульчилсан байхад журмын 4.1.4-д "жил бүр хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж, **эсхүл албан хаагчид зөвлөмж хүргүүлэх**;", 3.4.5-д "Гомдол гаргасан этгээд, **албан хаагчид** дэд хорооны дүгнэлт, **зөвлөмжийг хүргүүлэх**;", хуулийн 13.2-т "Нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг Ёс зүйн дэд хорооны гишүүнээр таван жилийн хугацаагаар сонгоно." гэж заасан байхад журмын 2.6-д "дэд хорооны нарийн бичгийн даргын чиг үүргийг гишүүд ээлжилж хэрэгжүүлэх ба хугацааг Дэд хороо батална" гэж хуулийн заалтыг өргөжүүлсэн.

iii)журмын 2.8-д "...ажлын 7 хоногийн дотор...", 6.13-т "... ажлын 2 хоногийн дотор ..." 6.18-д "...Ажлын 5 өдрийн дотор..." гэж ялгаатай томьёолсон.

iv)хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "Нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг Ёс зүйн дэд хорооны гишүүнээр таван жилийн хугацаагаар сонгоно." гэж заасан байтал журмын 2.8-д "... Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна" гэж хэт явцуурууулсан.

v)журмын 3.6-д "Хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого гарсан тохиолдолд Дэд хорооны дарга, гишүүн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу холбогдох байгууллагад мэдэгдэнэ." гэж заасан боловч Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд энэ талаар зохицуулалтгүй, аль байгууллагад хэрхэн мэдэгдэх талаар журамлаагүй нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдалд хүргэсэн.

vi)журмын 6.10-д "Дэд хороо гомдол, мэдээлэлд дурдсан асуудал бүрээр санал хурааж, **дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ**. Хэд хэдэн этгээдэд холбогдох нэг гомдол, мэдээллээр нэг шийдвэр гаргаж болно." гэснийг "ердийн олонх" гэж, 6.13-т "дүгнэлтийг ... 2 хоногийн дотор", 6.18-д "...дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэр гаргана" гэснийг боломжит хугацаа олгох шаардлагатай.

vii)журмын 6.18-д "Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэр гаргана." гэж заасан боловч мөн журмын 6.19-д "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн

15.1.5-д заасан дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдол, мэдээлэл гаргасан этгээд, түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор шууд харьяалах дээд шатны байгууллагын дэд хороонд гомдол гаргана.", 6.20-д "Тухайн байгууллага харьяалах дээд шатны дэд хороогүй бол гомдол, мэдээлэл гаргасан этгээд дүгнэлтийг түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор тухайн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтанд гаргана." гэсэн нь гомдол гаргах эрхийг хязгаарласан байна.

viii)хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т "Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Ёс зүйн хороо хуралдааны дэгээ өөрөө тогтоож болно." гэж, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.3-т Ёс зүйн дэд хорооны гишүүнийг "шийдвэрийн улмаас бусдын дарамт, шахалтад өртөхөөс хамгаалуулах" баталгаагаар хангуулах зохицуулалтыг журмын 6.3-т заасан "Дэд хорооны хуралдаан нээлттэй явагдана" гэсэн зохицуулалттай уялдуулж, практикт хэрэгжихүйц байдлаар журамлах шаардлагатай байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО